

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
НЭГДҮГЭЭР ЗОРИЛГО: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
Зорилт 1. Улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулна. / Аймгийн засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 4.1.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний 1.1/							
1.1.1	Нэгдсэн сүлжээнд холбогдоогүй сумдыг улсын бүртгэлийн онлайн сүлжээнд холбох	-	Онлайн сүлжээнд холбосон сумдын тоо	Хөвсгөл аймгийн нийт 20 сум улсын бүртгэлийн онлайн сүлжээнд холбогдсон.	Хөвсгөл аймгийн онлайн сүлжээнд холбогдоогүй Түнэл, Ханх, Шинэ-Идэр, Тариалан сумдыг улсын бүртгэлийн онлайн сүлжээнд холбосон байна.	Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоныг улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбох ажлын хүрээнд 2020 онд 20 сумыг холбосон бол 2021 онд Түнэл, Ханх, Шинэ-Идэр, Тариалан сумдыг улсын бүртгэлийн онлайн сүлжээнд холбосноор сумдыг онлайн сүлжээнд холбох ажлыг 100 хувь хийж гүйцэтгэсэн.	50%
1.1.2	Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн нэгдсэн		Тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаанаас	2020 онд хэлтсийн хэмжээнд ашиглагдаж буй	Улсын бүртгэлийн нэгдсэн мэдээллийн	Хэлтсийн болон сумдын албан хаагчдаас техник тоног төхөөрөмжийн	50%

	сүлжээ, мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хариуцах, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах	-	шалтгаалсан доголдлыг арилгасан тоо	техник, тоног төхөөрөмжид давхардсан тоогоор нийт 20 засвар үйлчилгээг хийсэн.	сан, техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа хангагдсан байна.	засвар үйлчилгээний 13 дуудлагыг хүлээн авч, бүртгэл хөтлөн 12т нь засвар үйлчилгээг үзүүлж, засварлах боломжгүй эх хавтан шатсан Рэнчинлхүмбэ сумын зөөврийн компьютерт дүгнэлт гарган УБЕГ-ын МТГ-т хүргүүлсэн. Мөн албан хаагчдын бүртгэл хөтлөхөд ашигладаг программтай холбоотой гарсан бүхий л асуудлыг тухай бүрт нь шийдвэрлэн ажилласан.	
1.1.3	Хэлтсийн үйлчилгээний танхимд цахим үйлчилгээний булан бий болгох	-	Цахим үйлчилгээний булангаар үйлчлүүлсэн үйлчилгээний тоо	-	Цахим буланг үйл ажиллагаанд хэрэглэж эхэлсэн байна.	Хэлтсийн үйлчилгээний танхимд цахим үйлчилгээний буланг бий болгосон. Цахим үйлчилгээний буланг үйл ажиллагаандаа хэрэглэж эхэлснээр цахим үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia”-ээс иргэд лавлагаа мэдээлэл авах, гадаад паспорт, иргэний үнэмлэх захиалах зэрэг үйлчилгээг авах боломжоор хангагдсан.	50%
1.1.4	Үйлчилгээний	-	-Цахим машин,	2020 онд И-	Цахим	Хэлтсийн	

	төлбөр, хураамжийг цахим машин, төлбөрийн системээр авах нөхцлийг бүрдүүлж, сурталчлан ажиллах		төлбөрийн системээр хийгдсэн төлбөр хураамжийн тоо; -Сурталчилсан байдал;	баримт апп, Киоск цахим төлбөрийн машинаар 75 иргэн үйлчилгээ авсан.	хэлбэрээр төлбөр төлсөн иргэдийн тоо нэмэгдсэн байна.	үйлчилгээний танхимд байрлах цахим буланг бий болгож үйл ажиллагаанд хэрэглэж эхэлснээр иргэд интернэт банк, мобайл банк ашиглан үйлчилгээний хураамжаа тушааж баримтаа хэвлэн өгөх боломжоор хангагдсан байна. Мөн Хаан банкинд байрлах “Киоск” цахим төлбөрийн машинаар үйлчилгээний хураамжаа төлж хэвшээд байна.	50%
--	--	--	--	--	---	--	-----

ХОЁРДУГААР ЗОРИЛГО: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ

Зорилт 2. Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чанартай үзүүлнэ.

2.2.1	Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөх	-	-Бүртгэлийн тоо	Өмнөх онд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 23907, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 1389, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 10380 бүртгэл	Улсын бүртгэл үнэн зөв хөтлөгдөж, иргэдэд хүртээмжтэй хүрсэн байна.	2021 оны 5-р сарын 25-ны байдлаар төрсний бүртгэл 1074, гэрлэсний бүртгэл 504, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 69, үүнээс захиргааны журмаар 17, шүүхийн журмаар 52, Үрчилсний бүртгэл 41, эцэг /эх/	50%
-------	--	---	-----------------	---	---	---	-----

				хийгдсэн.		<p>тогтоосны бүртгэл 77, Ургийн овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл 41, нас барсны бүртгэл 298, бүртгэл хийгдэж цахим мэдээллийн санд баталгаажсан байна. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэж нийт 7845 мэдүүлэг хүлээн авч холбогдох бүртгэлийг хөтлөн, материалыг архивт хүлээлгэн өгч ажиллалаа. Хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэж нийт 694 иргэн хуулийн этгээдийн материал хүлээн авч ажилласан байна. Иргэн, хуулийн этгээдийн 625 материалыг улсын бүртгэлийн цахим мэдээллийн</p>	
--	--	--	--	-----------	--	--	--

						ers програмд баяжилтыг холбогдох хууль, дүрэм журмын дагуу хийж гүйцэтгэсэн.	
2.2.2	Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдийн салбар төлөөлөгчийн газрыг бүртгэлжүүлж, гэрчилгээ олгох	-	-Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газрыг бүртгэсэн тоо; -Олгосон гэрчилгээний тоо;	2020 оны жилийн эцэст гадны аймаг нийслэлийн харьяа 4 салбар төлөөлөгчийн газар бүртгэж гэрчилгээ олгосон.	Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн бүртгэлтэй салбар төлөөлөгчийн газрыг урьд оны мөн үеэс 1%-иар нэмэгдүүлнэ.	Шинээр үүсгэн байгуулагдаж байгаа 3 салбар төлөөлөгчийн газрын материалыг хүлээн авч улсын бүртгэлд бүртгэн холбогдох маериалыг харьяалалын дагуу хүргүүлэв.	50%
2.2.3	Улсын бүртгэлийн байгууллагаас мэдээлэл, лавлагаа өгөх	-	-Улсын бүртгэлтэй холбоотой олгосон мэдээлэл, лавлагаа, нотлох баримтын тоо; -Эрхийн улсын түтгэлзүүлсэн бүртгэлийн тоо;	2020 онд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд 8656, хууль хяналтын байгууллагад 908 иргэний лавлагаа, мэдээллийг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд 88, хууль хяналын байгууллагад 37 хуулийн	Улсын бүртгэлтэй холбоотой үнэн зөв лавлагаа, мэдээлэл, нотлох баримтыг хуульд заасан хугацаанд олгосон байна.	Иргэний баримтын архивын лавлагаа, иргэдэд 3609, хууль хяналтын байгууллага болон бусад байгууллагад 392, албан хэрэгцээнд 693 лавлагааг олгосон байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн лавлагааны яаралтай үйлчилгээг ажлын 8 цагт, энгийн үйлчилгээг ажлын 5 хоногийн дотор гарган иргэдэд	50%

				<p>этгээдийн лавлагаа, мэдээлэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас 139 иргэн, хуулийн этгээдэд лавлагаа хуулбар, хууль хяналтын байгууллагад 114 албан бичгээр лавлагаа тус тус олгосон.</p>		<p>үйлчилж ажиллалаа. Тайлант хугацаанд Газар өмчлөх эрх болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн нийт 47 лавлагаа, хуулбар 5, тус тус олгосон байна.</p> <p>Эрх бүхий албан тушаалтан, хууль хяналтын байгууллагаас нийт 78 албан бичиг ирүүлсний дагуу хариуг цаг хугацаанд нь хүргүүлсэн байна. Төрийн албан хэрэг хөтлөлт стандартын дагуу төрийн байгууллагаас ирүүлсэн 16 хариутай албан бичиг, улсын бүртгэлийн ерөнхий газарлуу 4 албан бичигт хуулийн хугацаанд хариу өгөв.</p> <p>Иргэн, хуулийн этгээдийн лавлагаа 82, Төрийн байгууллагад лавлагаа 10 нийт 92 лавлагаа олгов. Иргэн, хуулийн этгээдэд хуулбар 8,</p>	
--	--	--	--	--	--	---	--

						Төрийн байгууллагад хуулбар 3, нийт 11 хуулбар олгосон байна.	
2.2.4	Санхүүгийн тайланг найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй хуулийн этгээдийг Сангийн яамны саналыг үндэслэн байгууллагын цахим хуудсаар нийтэд зарлан хуульд заасан хугацаанд улсын бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулах		-Санхүүгийн тайланг найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээх; - Баталгаажуулаагүй хуулийн этгээдийг Сангийн яамны саналыг хүлээн авах; -Байгууллагын цахим хуудсаар нийтэд зарлах; -Хуульд заасан хугацаанд улсын бүртгэлээс хасах	2020 оны жилийн эцсийн байдлаар 44 хуулийн этгээд татан буугдсан.	Улсын бүртгэлээс хасагдах хуулийн этгээдийг байгууллагын цахим хуудсаар нийтэд зарласан байна. Хуульд заасан хугацааны дараа хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах бүртгэл хөтөлсөн байна.	.Шинэчилсэн бүртгэлд хамргадаагүй хуулийн этгээдийн судалгааг аймгийн Татварын хэлтэс, санхүү, төрийн сангийн хэлтэсрүү хүргүүлж, тайлан мэдээ гаргадаг эсэх талаарх судалгааг авсан. Аймгийн Татварын хэлтсээс цахим санд бүртгэлийн боловч тайлан мэдээ гаргадаггүй 135 хуулийн этгээдийн судалгааг ирүүлсэний дагуу холбогдох мэдээллийг цахимаар хүргүүлэв.	50%
2.2.5	Төрийн бус байгууллагын тайланг хуулийн хугацаанд хүлээн авах	-	Төрийн бус байгууллагын тайланг	2020 онд Төрийн бус байгууллагын тайланг хуулийн хугацаанд	Төрийн бус байгууллагын тайланг хуулийн хугацаанд хүлээн	Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн төрийн бус байгууллагыг 23-н сумаар нь ялган excel файл	50%

	<p>Шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн судалгааг гаргах, Оноосон нэрийн баталгаажуулалт болон шинээр үүсгэн байгуулсан хуулийн этгээдийг цахимаар бүртгэх бэлтгэл ажлыг хангах</p>		<p>хуулийн хугацаанд хүлээн авсан эсэх, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн судалгааг гаргасан эсэх,</p>	<p>хүлээн авч ажилласан.</p>	<p>авч ажилласан байна.</p>	<p>үүсгэн сумдын улсын бүртгэгч нарт албан бичиг, тайлан ирүүлэх загвар хүснэгт, мөн тухайн сумданд үйл ажиллагаа явуулж байгаа 66 төрийн бус байгууллагын мэдээллийг хүргүүлэн ажилласан. Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж байгаа 209 төрийн бус байгууллагын үүсгэн байгуулагч нарт тайлангаа хуулийн хугацаанд ирүүлэх талаар утсаар зөвөлгөө өгч Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн faje хуудас, Хөвсгөл аймгийн хэмжээний төрийн бус байгууллагын нэгдсэн face групп / Хөвсгөл ТББ /-д төрийн бус байгууллагын тайлан ирүүлэх тухай мэдээлэл, тайлангын загвар маягыг тус тус байршуулан. Төрийн бус байгууллагын үйл ажиллагааны</p>	
--	---	--	---	------------------------------	-----------------------------	--	--

						тайлан ирүүлэх хуулийн хугацаанд 58 төрийн бус байгууллагын тайланг хүлээн авч нэгтгэн архивт хүлээлгэн өглөө.	
					Шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн судалгааг гарган холбогдох арга хэмжээг авсан байна.	Шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 135 хуулийн этгээдийн судалгааг аймгийн Татварын хэлтэс, санхүү, төрийн сангийн хэлтэсрүү хүргүүлж, тайлан мэдээ гаргадаг эсэх талаарх судалгааг авсан.	
					Оноосон нэрийн баталгаажуулалт болон шинээр үүсгэн байгуулсан хуулийн этгээдийг цахимаар бүртгэх бэлтгэл ажлыг хангасан байна.	Хэлтсийн үйлчилгээний танхимд цахим үйлчилгээний буланг бий болгосноор оноосон нэрийн баталгаажуулалт болон шинээр үүсгэн байгуулсан хуулийн этгээдийг цахимаар бүртгэх бэлтгэл ажлыг хангаад байна.	
2.2.6	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх, цахим лавлагаа олголтын системийг	-	Цахим лавлагаа олголтын системийг иргэдэд таниулах, хөгжүүлэлтэн	-	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй,	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэн цахим лавлагаа олголтын системийг	50%

	иргэдэд таниулах, хөгжүүлэлтэн дээр санал хүргүүлэх		дээр санал хүргүүлэх		түргэн шуурхай хүргэн цахим лавлагаа олголтын системийг иргэдэд таниулан, хөгжүүлэлтэн дээр холбогдох саналыг хүргүүлсэн байна.	иргэдэд таниулан, хөгжүүлэлтэн дээр холбогдох саналыг Улсын бүртгэлийн ерөний газрын ХЭУБГ-т хүргүүлэн ажиллалаа.	
2.2.7	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг суманд үзүүлж эхлэх бэлтгэл ажлыг хангах, судалгааг УБЕГазарт хүргүүлэх;	-	-Хүний нөөцийн судалгаа гаргаж, сумдын улсын бүртгэгч нарт цахимаар сургалт зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангах; -Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг суманд үзүүлж эхлэх;	Хөвсгөл аймагт сумаас эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж эхлээгүй байна.	Алслагдсан сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулсан байна.	Хүний нөөцийн судалгаа гаргаж, сумдын улсын бүртгэгч нарт цахимаар сургалт зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангасан бөгөөд Хөвсгөл аймгийн Тариалан, Галт сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг нэвтүүлэх тухай саналыг Эд хөрөнгийн бүртгэлийн газарт хүлгүүлсэн.	50%
2.2.8	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн хариуцлагын даатгалын гэрээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	-	-Гэрээний хэрэгжилтийн хувь;	“ХААН даатгал” ХХК-тай хамтарч бүртгэгч нарын хариуцлагын даатгал хийгдэж эхэлсэн.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарыг хариуцлагын даатгалд хамруулж,	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр ажиллаж буй нийт улсын бүртгэгч нарыг УБЕГ, Эд	50%

					гэрээний хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	хөрөнгийн улсын бүртгэлийн газар “ХААН даатгал” ХХК-тай гэрээ байгуулснаар Хөвсгөл аймгийн 3 улсын бүртгэгч, улсын ахлах бүртгэгч нар хариуцлагын даатгалд хамрагдан уг ажлын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
2.2.9	Мөрөн, Түнэл сумын хилийн цэст өөрчлөлт орсны улмаас эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний хаяг зайлшгүй солигдох иргэн, хуулийн этгээдийг судалгааг гаргаж хаягийн өөрчлөлт хийх ажлыг зохион байгуулах.	-	Хилийн цэсийн улмаас эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний хаяг солих иргэдийн судалгааг гаргаж хаягийг өөрчлөх ажлыг зохион байгуулсан эсэх.	- Хилийн цэсийн улмаас эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний хаяг солих иргэдийн судалгааг гаргасан.	. Мөрөн, Түнэл сумын хилийн цэст өөрчлөлт орсны улмаас эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний хаяг зайлшгүй солигдох иргэн, хуулийн этгээдийг судалгааг гаргаж хаягийн өөрчлөлт хийж гэрчилгээг сольж олгосон байна.	Мөрөн, Түнэл сумын хилийн цэст зөрчин олгогдсон иргэдийн нэр дээрхи өмчлөх эрхийг хаяг болон регистрийн дугаараар нь Ergs програмд шүүж үзэхэд газар өмчлөх эрхийн хувийн хэрэг бүртгэл 204, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн хувийн хэрэг бүртгэл 79, нийт 283 хувийн хэрэг бүртгэлийн судалгааг гарган хяналтын улсын байцаагчаар	50%

						дүгнэлт гаргуулан 43 хувийн хэрэг бүртгэлд хаягийн өөрчлөлт хийж гэрчилгээг бичиж олгосон байна.	
2.2.10	Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж буй “Түрээсийн орон сууцны хөтөлбөр”-ийн дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн суманд баригдсан “Шинэ мөрөн” хорооллын 135 айлын айлын түрээсийн орон сууцыг түрээсийн гэрээ, барьцааны гэрээнд тусгагдсан хууль, журмын дагуу бүртгэх	-	Уг гэрээтэй холбоотой Хөвсгөл аймгийн ЗДТГ, Аймгийн өмчийн газар, иргэдийн хооронд хийгдэж буй гэрээг хуульд нийцсэн эсэхэд хяналт тавин УБЕГ-тай хамтарч гэрээг улсын бүртгэлд бүртгэх		Тус гэрээ хэлцэл хуульд нийцсэн төдийгүй нотариатаар гэрчлэгдэн улсын бүртгэлд бүртгэгдэн баталгаажсан байна. Хуульд заасны дагуу гэрээг бүртгэж цахим мэдээллийн санд тусган хувийн хэрэгт баяжилт хийгдсэн байна.	Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж буй “Түрээсийн орон сууцны хөтөлбөр”-ийн дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн суманд баригдсан 135 айлын орон сууцнаас 9 иргэний түрээсийн гэрээний эрх, барьцааны гэрээг хууль заасан шаардлагыг хангуулан холбогдох бүртгэлийг хөтөлж цахим санд мэдээллийг тусган ажиллалаа. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас түрээсийн гэрээг түр хойшлуулсан байгаа тул бусад түрээсийн гэрээ бүртгэгдээгүй болно.	30%
2.2.11	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой гарын	-	МУ-ын Засгийн газрын 2020.12.23-ны	Засгийн 2010 оны 237 тогтоолын дагуу	Батлагдсан үнийн тарифыг иргэдэд сурталчлах	МУ-ын Засгийн газрын 2020.12.23-ны өдрийн №230	50%

	авлага, материалыг шинэчлэх, үнийн тарифыг шинэчилсэн самбар барнерийг үйлчилгээний танхимд шинэчлэн бий болгох		өдрийн №230 тогтоолоор баталсан үнэ тарифын дагуу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг хөтлөх	үйлчилгээний хөлсөө авч байгаа.	таниулах ажлыг зохион байгуулах	дугаар тогтоолоор баталсан үнэ тарифыг иргэдэд таниулах, сурталчлах зорилгоор 2021 оны 04 дүгээр сарын 19-нд “Хөвсгөл телевиз”-ээр мэдээлэл өгөв. Мөн гарын авлага, материалыг улсын бүртгэлийн хэлтсийн Фейсбүүк, пэйж хуудсаар түгээн дэлгэрүүлж ажиллалаа.	
2.2.12	Хаягжуулалтын журмын хүрээнд хаяг шинэчлэгдсэн иргэний цахим үнэмлэх, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ /хаяг/ солих ажлыг зохион байгуулах.	-	Хаяг шинэчлэгдсэний улмаас солих шаардлагатай: -иргэний цахим үнэмлэх солих; -хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт бүртгэх; -эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ солих.	-	Хаяг шинэчлэгдсэний улмаас солих шаардлагатай иргэний цахим үнэмлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ солих ажлыг зохион байгуулан, гэрчилгээ цахим үнэмлэхийг сольж олгосон байна.	Хаяг шинэчлэгдсэний улмаас солих шаардлагатай иргэний цахим үнэмлэх 15, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 87 гэрчилгээний хаяг сольж олгосон байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 24 гэрчилгээнд нэмэлт өөрчлөлтийг бүртгэн цахим санд оруулсан байна.	50%

Зорилт 3. Улсын бүртгэл болон улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулна.

2.3.1	Хяналт шалгалтын төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	2020 онд гэнэтийн болон төлөвлөгөөт бус 1 хяналт шалгалт хийж, 123 дүгнэлт гаргасан.	Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажилласан байна.	2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах ажлын хүрээнд иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг үнэн зөв хөтлөх, нотлох баримтыг хуульд зааснаар бүрдүүлэн авах, мэдээллийн санд үнэн зөв бүртгэх талаар цахим сургалтыг сумдын улсын бүртгэгч нарт 4 удаа зохион байгуулж улсын бүртгэлийн хууль, дүрэм журамд нийцсэн эсэхийг нэг бүрчлэн шалгаж ажиллалаа.	50%
2.3.2	Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн зөрчлийг арилгах	-	-Зөрчилтэй иргэдийн тоо; -Зөрчлийг арилгасан тоо;	2020 онд мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн 521 иргэдийн зөрчлийг УБЕГ-ын ИУБГ-т албан	Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн илэрсэн зөрчлийг 100% арилгасан	Мэдээллийн санд бүртгэгдсэн зөрчилтэй иргэдийн бүртгэлийг нягтлан шалгаж нийт хяналтын улсын байцаагчийн 42	50%

				бичиг хүргүүлж арилгуулсан.	байна.	удаагийн дүгнэлтээр 435 зөрчлийг арилган ажиллалаа.	
2.3.3	Улсын бүртгэлийн үйл ажиллагааны явцад гарах зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	-	Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд гарах зөрчлийг бууруулсан тоо;	2020 онд нийт 21428 бүртгэлд хяналт шалгалт хийж, 672 зөрчил илрүүлж арилгасан.	Улсын бүртгэлийн үйлчилгээ иргэн, хуулийн этгээдэд тэгш, хүртээмжтэй, чирэгдэлгүй хүрсэн байна.	Улсын бүртгэгч нарт 5 удаагийн цахим сургалтыг хийж зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан	50%
2.3.4	Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх	-	Шалган шийдвэрлэсэн зөрчлийн тоо;	2020 онд Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн нийт 422 иргэн, хуулийн этгээдийн зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж, торгох шийтгэл оногдуулан 13.020.000 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн	Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн тоо буурсан байна.	Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлж 160 иргэнд торгуулийн арга хэмжээ авч нийт 4.800.000 төгрөгийн торгууль ногдуулсан.	50%
2.3.5	Аймгийн хэмжээнд иргэний байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн зөрчил арилгах ажлыг зохион байгуулах	-	Арилгасан зөрчлийн тоо;	2020 онд оршин суугаа хаягийн зөрчилтэй 151 бүртгэлийн зөрчлийг арилгасан.	Иргэний оршин суугаа газрын хаягийн зөрчлийг арилгасан байна.	Мөрөн Түнэл сумын хилийн цэс өөрчлөгдсөнөөс улсын бүртгэлийн мэдээллийн сан, улсын бүртгэлийн гэрчилгээний бичвэр буруу 305 бүртгэлийн зөрчлийг дүгнэлт	50%

						үйлдэн мэдээллийн сангийн зөрчлийг арилгаж, иргэдийн хүсэлтийн дагуу 43 хувийн хэрэг бүртгэлд хаягийн өөрчлөлт хийж гэрчилгээг бичиж олгосон байна.	
2.3.6	1.2.7.Хэлтсийн болон сумдын улсын бүртгэгч нарыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, чадваржуулах чиглэлээр сургалт зохион байгуулах		Бүртгэлийн зөрчил буурсан, улсын бүртгэгч нарын эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.	Эрх зүйн сургалтыг 3 удаа зохион байгуулсан.	Эрх зүйн сургалтыг 2 удаа зохион байгуулсан байна	Хэлтсийн болон сумдын улсын бүртгэгч нарыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, чадваржуулах зорилгоор 5 удаагийн цахим сургалт зохион байгуулсан.	50%
Зорилт 4. Иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой архивын эх нотлох баримт бичгээр архивын сан хөмрөг бүрдүүлж, баяжилт хийж, түүний хадгалалт хамгаалалтыг сайжруулна.							
2.4.1	Архивын байрны хадгалалт, хамгаалалт, хадгаламжийн сангийн нөхцөл байдлыг сайжруулах	-	Архивын стандартын хэрэгжилтийн хувь;	2020 онд архивын байрны хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг ханган ажиллаж иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн нийт 12261 хувийн хэрэг материалыг архивт байрлуулсан байна.	Архивын стандартын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.	Архивын баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдалд байнгын хяналт тавин ажиллаж, галын аюулгүй байдлын самбар, галын буланг шинэчлэн байрлуулсан.	50%
2.4.2	Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн	-	-Тоолсон иргэний	2020 оны жилийн эцэст		Хөвсгөл аймгийн хэмжээнд эд	50%

	улсын бүртгэлийн баримтын архивын тооллого хийж, баримтыг данс бүртгэлжүүлэх		баримтын тоо; -Тоолсон хуулийн этгээдийн хувийн хэргийн тоо; -Тоолсон эд хөрөнгийн хувийн тоо;	иргэн, хуулийн этгээдийн 2446, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 32904, иргэний баримтын архивт 126131 хувийн хэрэг тус тус хадгалагдаж байна.	Хэлтсийн иргэний баримтын архивыг 100% тоолсон байна.	хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 2021 оны эхний хагас жилийн байдлаар 899 хувийн хэрэг шинээр бүртгэгдэн цахим мэдээллийн санд тусгагдан нийт 34734 цаасан суурьт хадгаламжийн нэгж архивын стандартын дагуу хадгалагдаж байна. 2021.05.25 байдлаар хуулийн этгээдийн архивт цахим санд бүртгэлтэй 2493 , татан буугдсан 290 шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 135 нийт 2918 хуулийн этгээдийн хувийн хэрэг байршиж байна. Иргэний баримтын архивт 136583 хувийн хэрэг хадгалагдаж байна. Иргэний баримтын архивын хувийн хэргийн тооллогын бэлтгэл ажлыг ханган өргөн 50см өндөр 2м, урт 2.80м-ийн 2ш төмөр тавиур шийдүүлсэн.	
2.4.3	Байгууллагын БНШАЗК-ын үйл ажиллагаанд хяналт тавих, хэлтсийн 2021 онд хөтлөх хэргийн	-	-Жагсаалтыг эцэслэн батлуулсан эсэх;	Тус хэлтэс нь хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж,	Жагсаалтыг үйл ажиллагаандаа мөрдсөн байна.	Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Архивын ерөнхий газрын	50%

	<p>нэрийн жагсаалтыг боловсруулж, батлуулах, хөтлөгдөж дууссан баримт бичгийг устгах ажлын зохион байгуулах</p>		<p>-Устгасан баримт бичгийн тоо;</p>	<p>батлуулан ажиллаж байгаа бөгөөд , хөтлөгдөж дууссан баримт бичгийг устгах ажлыг тухай бүр зохион байгуулан ажиллаж байна.</p>		<p>даргын хамтарсан 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/1437, А/110 дугаар тушаалын хавсралт, Улсын бүртгэлийн нэгдсэн архивын даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 11/622 чиглэл, зөвлөмжийг үндэслэн тус хэлтсийн баримт бичиг нягтлан шалгах комисс 2021 оны 03 сарын 15-ны өдөр хуралдаж, иргэний баримтын архив, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт хадгалагдаж байсан хадгалах хугацаа нь дууссан ИУБ-21, шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэр, иргэний үнэмлэх олголтын дэвтэр, гадаад паспорт олголтын бүртгэлийн дэвтэр, лавлагаа, лавлагаа олгосон бүртгэлийн дэвтэр, хүчингүй болсон гэрчилгээг, архиваас түр олгох баримтын</p>	
--	---	--	--------------------------------------	--	--	---	--

						бүртгэлийн дэвтэр архиваас түр олгох эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн хувийн хэргийн бүртгэл маягт А-2, Эд хөрөнгө бүртгэлтэй эсэх, барьцаатай эсэх архивын лавлагаа /иргэд аваагүй хугацаа хэтэрсэн лавлагаа/ захиалгын хуудас зэргийг акт үйлдэж устгах шийдвэр гаргасан, үүний дагуу 2021.04.13-ны өдрийн 15:00 – 16:30 цагийн хооронд Мөрөн сумын хогийн цэгт комиссын гишүүдийг байлцуулан шатааж устгалд оруулсан.	
2.4.4	Иргэний баримтын архивын хадгаламжийн нэгж, хувийн хэргийг цэгцлэх зорилгоор 1995-2004 оны ХААТР-11 маягтыг мэдээллийн санд шалгах	-	Бусад аймаг нийслэлд бүр мөсөн шилжин явсан иргэдийн хувийн хэргийг харъяалалын дагуу хүргүүлсэн эсэх	2020 онд 2003- 2004 оны төрсний бүртгэлийн 612 ХААТР-11 маягтыг мэдээллийн санд тулган шалгаж эцэг эхийн мэдээлэл зерүүтэй болон бүртгэгдээгүй байсан 116	Иргэний баимтын архивын хадгаламжийн нэгж, хувийн хэргийг цэгцлэх зорилгоор 1995- 2004 оны ХААТР-11 маягтыг мэдээллийн санд шалгаж,	Мөрөн сумын 1997- 2002 оны тодорхойгүй төлөвтэй, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй иргэдийн ХААТР-11 маягтыг Иргэний бүртгэлийн мэдээллийн санд шалгаж нийслэлрүү шилжин явсан 136	50%

				иргэний зөрчлийг арилган ажилласан.	шилжсэн иргэдийн хаатр маягтыг бусад аймаг хот руу шилжүүлсэн байна.	иргэний ХААТР маягтыг улсын бүртгэлийн нэгдсэн архивт хүргүүлж мөн бусад аймаг, хотруу шилжин явсан 33 иргэний холбогдох хувийн хэргийг аймгуудийн улсын бүртгэлийн хэлтэст хүргүүллээ. 127 иргэний ХААТР-11 маягтыг галигийн дагуу хувийн хэрэгт баяжилт хийж, нас барсан 7 иргэний хаатр маягтыг баяжилт хийж ажиллалаа.	
2.4.5.	Архивын өрөө, тавиурын хүртээмж, дүүргэлтийн судалгааг гаргаж УБЕГ-т хүргүүлэх, нягтруулсан шүүгээний тоог нэмэх	-	-Ажлын хэсэг байгуулах; -Архивын байрны хадгалалт, хамгаалалт, хадгаламжийн сангийн нөхцөл байдлын талаарх судалгаа гаргах	- 2020 онд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн архивт 1 ширхэг төмөр тавиур хийлгэсэн.	Архивын өрөө, тавиурын хүртээмж, дүүргэлтийн судалгааг гаргаж УБЕГ-т хүргүүлэх, тавиур, нягтруулсан шүүгээний тоог нэмсэн байна.	Архивын баримтын хадгалалт аюулгүй байдалд байнгын хяналт тавин ажиллаж, архивын өрөө, тавиурын хүртээмж, дүүргэлтийн судалгааг гаргаж УБЕГ-т хүргүүлж, УБЕГ-ын нэгдсэн архивын газраас эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт 5 ширхэг,	50%

						иргэний баримтын архивт 2 ширхэг төмөр рамтай тавиур авчран архивт байрлуулан өдөр тутмын баяжилтаа хийж байна.	
ГУРАВДУГААР ЗОРИЛГО: ХУУЛИАР ОЛГОСОН ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
3.1.1	Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар УБЕГ-аас гаргасан нарийвчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах, дэд төлөвлөгөө батлах	-	-Нарийвчилсан төлөвлөгөөний биелэлтийн хувь; -Дэд төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	-	Сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө болон дэд төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлсэн байна.	Монгол улсын ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Улсын бүртгэлийн хэлтсийн хийж хэрэгжүүлэх ажлын дэд төлөвлөгөөнд туссан ажлууд 100 хувь хийгдэж Монгол улсын ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг амжилттай зохион байгуулж, ирц бүртгэлийн тоног төхөөрөмжийг УБЕГазарт хүлээлгэн	100%

						өгч ажиллалаа.	
3.1.2	Хууль тогтоомжийн дагуу холбогдох этгээдэд улсын бүртгэлийн мэдээ тайлан, мэдээлэл хүргүүлэх	-	-Хууль тогтоомжийн дагуу мэдээ, тайланг үнэн, зөв гаргасан байх; -Мэдээ, тайланг хугацааны хувьд хоцрогдолгүй хүргүүлэх;	-	Холбогдох мэдээ, мэдээллээр хангаж ажилласан байна.	Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн ирц бүртгэлийн явцын мэдээг аймгийн 129 хэсгийн хороогоор нэгтгэн 11:00, 15:00, 22:00 цагуудад Улсын бүртгэлийн Ерөнхий газрын бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газарт хүргүүлэн ажиллалаа.	100%

ДӨРӨВДҮГЭЭР ЗОРИЛГО: ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Зорилт 5. Улсын бүртгэлийн байгууллагын удирдлагын менежмент, хүний нөөцийн төлөвлөлтийг сайжруулж, мэргэжлийн боловсон хүчний чадавхыг дээшлүүлнэ.

4.5.1	Хэлтсийн даргын Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах	-	-Гүйцэтгэлийн төлөвлөгөөг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар хянуулсан эсэх; -Гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд холбогдох газруудад хүргүүлсэн эсэх;	2020 онд гүйцэтгэлийн төлөвлөгөө 92,8 хувьтай хэрэгжсэн.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна.	2021 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар батлуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хяналтандаа авч хэрэгжилтийг ханган ажиллаж	50%
-------	---	---	---	--	---	---	-----

						байна.	
4.5.2	“Хэлтсийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөө 2021”-ыг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах	-	-Сургалтын төлөвлөгөө батлагдсан эсэх; -Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	Хэлтсийн 2020 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг 2020 оны 01 сарын 23-ны өдөр хэлтсийн даргаар батлуулан, биелэлтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөнд тусгасан ажлууд хугацаандаа биелсэн.	Төлөвлөгөөний дагуу сургалтууд зохион байгуулагдаж, хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	2021 оны хэлтсийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажилласан ба Ковид-19 цар тахалтай холбогдуулан танхимаар сургалт зохион байгуулах боломжгүй тул сумдын улсын бүртгэгч нарт 5 удаагийн онлайн сургалт зохион байгууллаа. Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажил, сонгуулийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан эрх зүйн сургалтыг 2021 оны 05 сарын 11-12 ны өдрүүдэд онлайн хэлбэрээр Хэлтсийн дарга Б.Эрдэнэбилэг Иргэний улсын бүртгэлтйн тасгийн дарга, Улсын ахлах	50%

					<p>бүртгэгч Б.Өлзийням, Тагнуулын хэлтсийн ажилтан Г.Түмэнжаргал нар удирдан зохион байгууллаа. 2021.05.19-нд аймгийн нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаарх сургалтыг авч нийт албан хаагчдыг хамруулсан. 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Аймгийн Биеийн тамир, спортын газрын ахлах арга зүйч Б. Ганчимэгийг урин “Идэвхтэй хөдөлгөөн ба суугаа хэв маяг” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. 2021.02.23-онд Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн газраас Холбооны бүгд найрамдах герман улсын Барут/Марк хотоос Мөрөн хотод хэрэгжиж буй “ KCS-058-.BARUT/MARK-2020” төслийн хүрээнд төрийн</p>	
--	--	--	--	--	---	--

